



Уран нийтлэл

Суралцахуйн зорилт: Уран нийтлэлийн бүтэц, гол санааг цогцолбор, түлхүүр үг, өгүүлбэрээр тодорхойлох

1. Нийтлэлийн бүтэц, сэдэв, гол санааг тодорхойлох
2. Нийтлэлийн утга, бүтцийн холбоо хамаарлыг задлан шинжилж, онцлогийг тайлбарлах



Миний эх орон – миний тоонот

Уран нийтлэл гэж юу вэ?

Зохиогчийн уран сэтгэмж, үзэл бодол, үнэлэмж дүгнэлт давамгайлсан олон түмний урмыг сэргээж, ухааныг тэлсэн чөлөөт уран зураглал, бодит баримт хоёрыг хослуулсан тайлбар бүхий нийтлэл- уран сайхны богино эх юм.

Улс төрийн уран нийтлэл


Уянгын уран нийтлэл

Байгаль нийгмийн хөгжлийн зүй тогтол, хүний амьдралын утга учир, хүн байгалийн харилцаа холбоо, хүний сэтгэлийн нарийн нандин бодол, санааг туйлдаа хүртэл цэнэгшсэн тунгаамал үгээр гаргадаг.

Уран нийтлэлийн утга, бүтцийн онцлог




Эхлэл
хэсэг



Уншигчийг хөтлөх чадалтай байх, бодит хэрэг явдлаас асуудлыг дэвшүүлэх




Гол
хэсэг



Асуудлыг агуулгын ямар нэг зөрчилгүйгээр, итгэл үнэмшилтэй, тодорхой, уран яруу, дүрсэлсэн байх, үнэлгээ дүгнэлт, баримтын харьцаа



Төгсгөл
хэсэг



тэнцвэртэй байх
Үндсэн хэсэгт гаргасан санаагаа зангидах, ухаарал өгөх

Уран нийтлэлийн бүтэц, агуулгын хамаарал

Эхлэл
хэсэг

Сонирхолтой эхлэл
Дэвшүүлсэн асуудал

Гол
хэсэг

Зохиогчийн бүтээсэн уран зураглал,
уран сэтгэмж, үнэлгээ дүгнэлт,
хандлага, үзэл бодол, баримт

Төгсгөл
хэсэг


Дэвшүүлсэн асуудал, баримт,
үзэл бодлыг дүгнэх

Аян замын алжаал, байгалийн сайхан дундах бодрол маягаар эхлээд, “Энэ сайхан эх орон чинь хаанаас эхэлсэн билээ? гэсэн асуултаар асуудлаа дэвшүүлээд, “Эх орон тоонот хэмээх тохмын чинээхэн газраас эхэлж, эх орноо би таньж эхэлсэн” гэжээ.

Эх орны 4 зүгт буй байгалийн гоо үзэсгэлэнгийн зураглал, түүний талаарх өөрийн сэтгэгдэл, мэдрэмж, үнэлгээ дүгнэлтийг баян тансаг үг хэлээр уярал ухаарал өгөхүйц бодлоор хөтлөн эх болсон газар нутгаа яруу дүрсэлжээ.

Эх орны орны минь хаана ч бай, миний төрсөн гэр, миний төрсөн газар хэмээн “тоонот” гэдэг үгээр төлөөлүүлэн адилтгаж, хүн байгалийн мөнхийн нандин шүтэлцээг харуулжээ.

Дэвшүүлсэн асуудал - баримт - дүгнэлтийн уялдааг загварчилж, нийтлэлийн зохиомжийн онцлогийг харуулаарай.



Уран нийтлэлийн үгийн сангийн онцлог

Уран нийтлэл нь үгээр уншигчийг татаж, сэтгэлийг нь хөдөлгөж, урам хайрлаж, ухааруулан сэнхрүүлдэг учир үг сонголт хамгийн чухал байдаг.

1.

Уншигч нь олон нийт учраас уншигчийн төлөө үг нэг бүрээ зориулах ёстой.

Уйгагүй сайжруулалт хийхийг шаарддаг.

Уншигчдад ойлгомжтой байхыг шаарддаг.

2.

Нийтэд ойлгомжгүй мэргэжлийн үг, нэр томъёог хэрэглэхгүй байх ёстой.

3.

Үгийн сангийн хувьд албаны болоод гадаад үгийг олноор хэрэглэхгүй байх ёстой.

Монгол хүний оюун ухаанд шингэмэл , өөриймссөн хэллэгтэй байхыг шаарддаг.

Уншигчдад урам хайрлаж, нөлөөлөхийг шаарддаг.

4.

Уран нарийн, хурц дайчин үгийн нөлөөгөөр ятган итгүүлдэг.

Анхаарлаа хандуулсан
сурагч та бүхэндээ
баярлалаа.